

## **ЕВРОПЫН ХОЛБОО, МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

*Ч.Цэрэннадмид\**

Аливаа жижиг улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн төлөвт дотоод хүчин зүйлээсээ гадаад хүчин зүйл илүү нөлөөтэй тусдаг гэж судлаачид дүгнэн хэлсэн байдаг.

XX зууны 90-ээд оноос эхлэн Монгол орон хөгжлийн шинэ шат болох иргэний, хүмүүнлэг ардчилсан нийгэмд шилжин, хүн төрөлхтөний үнэт зүйл болсон ардчилал, хүний эрхийг дээдэлсэн, чөлөөт эдийн засгийн харилцаа бүхий хөгжлийн замыг сонгосон билээ. Хөгжлийн энэ шинэ нөхцөл байдал нь Монголын нийгмийн амьдралын олон талт асуудлуудыг цоо шинээр харж, өөрийн орны өвөрмөц онцлог байдлыг харгалзан үзэж, улс орноо хөгжүүлэхийг шаардаж байна. Энэ нь манай улсын гадаад худалдааны салбарт ч мөн хамааралтай билээ.

Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого /2007-2021 он/-ын хүрээнд гадаад худалдааны салбарт дараахь стратегийн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө:
  - эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
  - оюуны шингэц бүхий бага оврын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг өсгөх;
- Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна:
  - импортлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;
  - өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжих;

Манай улсын гадаад бодлого 1990-ээд оноос хойш АНУ, Япон, Европын Холбооны улсууд зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн идэвхитэй харилцааг хөгжүүлэхэд чиглэж, онцгой ач холбогдол өгч байгаа нь гуравдагч бусад орны бодит сонирхол буюу нөлөөг өөртөө бий болгох замаар газар зүйн байрлалаас шалтгаалсан худалдаа, эдийн засгийн хязгаарлагдмал орчныг даван туулах, үндэсний аюулгүй байдлаа хангах гэсэн зорилгыг агуулж байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд АНУ, Япон, Европын Холбооны гишүүн улсууд зэрэг өрнө дорнын өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн

\* Ч.Цэрэннадмид - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгох, тэдгээртэй харилцан ашигтай хамтран ажиллах шаардлага байгаа билээ.

Нэг . Монгол Улсын Гадаад Худалдааны өнөөгийн байдал, ЕХ-ны гишүүн улсуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа


Манай улсын гадаад худалдаа ДНБ-д 30 орчим хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг хангахад худалдаа ихээхэн нөлөөтэй гэдгийг харуулж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн үед хийсэн томоохон шинэчлэл нь худалдааг либеральчилсан явдал юм. Монгол Улс худалдааны салбарт нийт 38 олон талт болон хоёр талын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байдаг.

Монгол Улсын ҮСХ-ноос гаргадаг Статистикийн эмхэтгэл, Гаалийн Ерөнхий Газрын мэдээ, судалгаанд үндэслэн манай орны гадаад худалдааны нийт бараа эргэлтийг тивээр нь авч үзвэл 56.0 орчим хувь нь Ази тивд, 37.0 орчим хувь нь Европ тивд, 7.0 орчим хувь нь Америк тивд, 0.4 хувь нь Австрали тивд тус тус ногдож байна. 2008 онд 2007 оныхоос Ази, Америк тивд ногдох хэмжээ нь буурч, Европ тивд ногдох хэмжээ өсч байгаа нь харагдаж байна (*Хүснэгт 1*). ЕХ-ны гишүүн улсуудтай хийж буй гадаад худалдаанд Их Британи, Франц, Итали, Герман улсууд голлох үүрэг гүйцэтгэж байна.


**Гадаад худалдааны нийт эргэлт, тивээр (Хүснэгт 1)**

| Тив          | Орны тоо | 2007            |          | 2008            |          |
|--------------|----------|-----------------|----------|-----------------|----------|
|              |          | (сая ам.доллар) | хувь (%) | (сая ам.доллар) | хувь (%) |
| Европ тив    | 40       | 1 194.2         | 29.8     | 2 126.6         | 36.8     |
| Ази тив      | 40       | 2 437.1         | 60.8     | 3 218.1         | 55.7     |
| Америк тив   | 19       | 355.6           | 8.9      | 412.3           | 7.1      |
| Австрали тив | 2        | 21.2            | 0.5      | 19.5            | 0.4      |
| Африк тив    | 9        | 1.2             | 0.0      | 2.5             | 0.0      |
| Нийт         | 110      | 4 009.3         | 100.0    | 5 779.0         | 100.0    |

**Импорт, голлогч орнуудаар (Зураг.1)**



**Экспорт, гол түнш орнуудаар (Зураг.2)**



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар, Үндэсний Статистикийн Хорооны тоон мэдээ

**Экспорт, импорт, бүсээр, оны үнээр\* (Хүснэгт 2)**

| Бүс                     | Region                | 2005                  | 2006           | 2007           | 2008           |
|-------------------------|-----------------------|-----------------------|----------------|----------------|----------------|
| <b>Нийт эргэлт</b>      |                       | <b>Total turnover</b> |                |                |                |
| <b>Бүгд</b>             | <b>Total</b>          | <b>2 249.2</b>        | <b>2 977.0</b> | <b>4 009.3</b> | <b>5 779.0</b> |
| Ази                     | Asia                  | 1 127.8               | 1 741.6        | 2 437.1        | 3 218.1        |
| Эзүн өмнөд              | Southeast             |                       |                |                |                |
| Азийн орнууд            | Asian countries       | 31.9                  | 43.0           | 68.1           | 108.7          |
| Ойрхи Дорнодын орнууд   | Middle East countries | 21.2                  | 16.9           | 25.6           | 27.7           |
| Европ                   | Europe                | 745.9                 | 864.7          | 1 194.2        | 2 126.6        |
| <b>Европын холбоо</b>   | <b>European Union</b> | <b>252.2</b>          | <b>228.1</b>   | <b>338.1</b>   | <b>727.0</b>   |
| Америк                  | America               | 337.1                 | 351.4          | 355.6          | 412.3          |
| Африк                   | Africa                | 0.4                   | 0.3            | 1.2            | 2.5            |
| Австрали                | Australia             | 30.0                  | 19.0           | 21.2           | 19.5           |
| <b>Экспорт /Export/</b> |                       | <b>Total</b>          |                |                |                |
| <b>Бүгд</b>             | <b>Total</b>          | <b>1 063.9</b>        | <b>1 542.0</b> | <b>1 947.5</b> | <b>2 534.5</b> |
| Ази                     | Asia                  | 602.9                 | 1 086.4        | 1 480.6        | 1 706.8        |
| Эзүн өмнөд              | Southeast             |                       |                |                |                |
| Азийн орнууд            | Asian countries       | 0.7                   | 2.4            | 1.2            | 2.5            |
| Ойрхи Дорнодын орнууд   | Middle East countries | 17.6                  | 4.1            | 8.9            | 8.2            |
| Европ                   | Europe                | 171.1                 | 164.6          | 185.9          | 528.5          |
| <b>Европын холбоо</b>   | <b>European Union</b> | <b>131.6</b>          | <b>107.9</b>   | <b>118.8</b>   | <b>434.4</b>   |
| Америк                  | America               | 275.5                 | 290.5          | 279.2          | 297.3          |
| Африк                   | Africa                | 0.1                   | 0.1            | 0.6            | 1.1            |
| Австрали                | Australia             | 14.3                  | 0.4            | 1.2            | 0.8            |
| <b>Импорт /Import/</b>  |                       | <b>Total</b>          |                |                |                |
| <b>Бүгд</b>             | <b>Total</b>          | <b>1 177.3</b>        | <b>1 435.0</b> | <b>2 061.8</b> | <b>3 244.5</b> |
| Ази                     | Asia                  | 524.9                 | 655.2          | 956.5          | 1 511.3        |
| Эзүн өмнөд              | Southeast             |                       |                |                |                |
| Азийн орнууд            | Asian countries       | 31.2                  | 40.6           | 66.9           | 106.2          |
| Ойрхи Дорнодын орнууд   | Middle East countries | 3.6                   | 12.8           | 16.7           | 19.5           |
| Европ                   | Europe                | 574.8                 | 700.1          | 1 008.3        | 1 598.1        |
| <b>Европын холбоо</b>   | <b>European Union</b> | <b>120.6</b>          | <b>120.2</b>   | <b>219.3</b>   | <b>292.6</b>   |
| Америк                  | America               | 61.6                  | 60.9           | 76.4           | 115.0          |
| Африк                   | Africa                | 0.3                   | 0.2            | 0.6            | 1.4            |
| Австрали                | Australia             | 15.7                  | 18.6           | 20.0           | 18.7           |

Эх сурвалж: ҮСХ-ны 2008 оны Статистикийн эмхэтгэл

Европын Холбоо нь жижиг, эмзэг эдийн засагтай, далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын худалдаанд учирч байгаа бэрхшээлийг онцлон авч үзэж, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чиглэлээр худалдааны бодлого явуулдаг.

Манай улс далайд гарцгүй, ЕХ-ны гишүүн орнуудын зах зээлээс алслагдмал оршлогоос үүдэн олон улсын транзит тээврийн их хэмжээний зардал манай экспортын өртгийг нэмэгдүүлдэг үндсэн хүчин зүйлийг бодолцоход, Европын орнуудын зах зээлд нийлүүлэх барааны гаалийн татварын хэмжээ Монгол Улсын хувьд харьцангуй өндөр тариф байлаа.

Европын Холбоо 2005 оны 6 дугаар сарын 27-нд 2006-2008 онд мөрдөх тарифын хөнгөлөлтийн журмаа баталсан юм. Энэхүү шинэ журмын дагуу “сайн засаглал, тогтвортой хөгжлийн” болзлыг хангасан, эмзэг эдийн засагтай орныг GSP-д хамрагдсан 7200 нэр төрлийн барааны гаалийн татвараас чөлөөлөх шинэ хөнгөлөлт /GSP+/ бий болгосон юм. ЕХ нь хөгжиж байгаа орнуудаас 14 оронд GSP+ хөнгөлөлт олгохоор шийдвэрлэсний дотор Азийн бүс нутгаас Монгол болон Шри Ланка улс багтаж байна.

Ингэснээр манай улс 2005 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн 7000 гаруй нэр төрлийн барааг ЕХ-ны орнуудын зах зээлд гаалийн татваргүйгээр оруулах боломж бүрдсэн юм.

Монгол бараа бүтээгдэхүүн хөнгөлөлттэй тариф эдэлдэг ч тээвэрлэлтийн зардал өндөр байгаа нь манай улсын экспортын барааны өрсөлдөх чадварт муугаар нөлөөлж байна.

Европын Холбооны зүгээс Монгол Улсад 2002-2006 онд үзүүлсэн тусламж нь хөдөөгийн хөгжил тэр дундаа мал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах, зах зээлийг өргөтгөхөд чиглэгдэж байсан юм. 2002-2004 оны хооронд ТАСИС хөтөлбөрийн хүрээнд фермийн аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн боловсруулалтыг сайжруулахад 6 сая еврогийн тусалцаа үзүүлсэн байна. Үлдсэн 9 сая еврогийн тусламжийг 2004-2006 оны хооронд Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулжээ.

2004 оноос хойш буюу 2004-2006 онуудад Ала хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чиглэсэн 9 сая еврогийн тусалцааг үзүүлэхээр шийдвэрлэсэн байна. Европын Холбоо, Монгол Улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлсон албан уулзалтын хүрээнд 2007 оны 5 сард Монгол Улсын гадаад хэргийн сайд Н.Энхболд, ЕХ-ны хөрш орнуудын харилцаа эрхэлсэн газрын дарга н.Бэниита Ферроро Валднертэй уулзаж, хоёр

талын хамтын ажиллагааны өнөөгийн байдал хийгээд 2007-2010 хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Монгол Улс, ЕХ-ны зүгээс 14 сая еврогийн тусламж авах ХОСБ-т гарын үсэг зурж буй Азийн анхны улс юм.

Европын Холбооны зүгээс үзүүлж буй техникийн туслалцааг Дэлхийн Банк, Монгол Улсын засгийн газар хамтран зохицуулалт хийж, хөдөө орон нутагт тогтвортой амьжиргааг бий болгох, тухайлбал бэлчээрийн эрсдлийн менежментийг сайжруулах, орон нутгийн иргэдэд жижиг эзэл, бага хэмжээний буцалтгүй тусламж олгох замаар зарцуулж байгаа юм.

## 2. Монгол Улсад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтад ЕХ-ны орнуудын эзлэх байр суурь

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудал хөгжингүй улс орнуудад төдийлэн хурц тавигддаггүй байхад хөгжиж буй орнуудад тухайн асуудлыг нухацтай авч үздэг байна.

Өнөөдөр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын гадаад болоод дотоод эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн бөгөөд тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай болж байна.

Сүүлийн үед жилд дунджаар 230-350 сая ам.долларт хүрч, эдийн засгийн өсөлт бий болж байна. Чингэхдээ Монголд оруулсан ГШХО-ын 64% зүүн Азийн бүс нутгийн орнуудад ногдож байгаагаас харахад Европын Холбооны улсуудаас Монголд оруулсан шууд хөрөнгө оруулалт төдийлөн их хувь эзэлдэггүй байна.

1990-2008 оны хооронд Монгол Улсад оруулсан ГШХО-ын 6.2 хувийг Европын Холбооны гишүүн 18 орны хөрөнгө оруулалт эзэлж байна. / Хүснэгт 3/

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-ийн мэдээгээр 2000-2003 онд гадаадын шууд хөрөнгө оруулалттай 1.7 мянган аж ахуйн нэгж байгуулагдсан бол 2004-2007 онд нилээд өсч, 3.2 мянган аж ахуйн нэгж буюу 2.9 дахин өссөн байна.

Харин гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 2000-2003 онд 593.5 сая ам.доллар байсан бол 2004-2007 онд 1380.4 сая ам.доллар болж даруй 2.3 дахин өссөн байна.

## Монгол Улсад бүртгэгдсэн ГШХО – 1000 ам.доллараар (хүснэгт 3)

| Улсын нэр  | Дүн<br>/ 1990-2007 / |     | 1995     | 1996     | 1997     | 1998     | 1999      | 2000     | 2001     | 2002     | 2003     | 2004     | 2005     | 2006     | 2007      | 2008     |
|------------|----------------------|-----|----------|----------|----------|----------|-----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|-----------|----------|
| Их Британи | 52 767 43            | 1 7 | 116 08   | 2 001.01 | 3 850.00 | 1 322.30 | 3 259.68  | 6 127.02 | 2 051.40 | 1 772.69 | 374.00   | 7 455.30 | 6 347.90 | 9 013.40 | 2 429.00  | 6 057.60 |
| Болгар     | 30 824 98            | 1.0 | 20.25    |          | 221.87   | 1 935.86 | 21 453.77 | 12.00    | 7 133.28 |          | 6.00     | 245      | 0.00     | 17.00    | 15.00     | 7.50     |
| Итали      | 16 425 15            | 0 5 | 7 235.75 | 130.00   | 241.40   | 419.50   | 2 140.35  | 20.00    | 6.00     | 41.65    |          | 31.70    | 5 219.43 | 44.90    | 37.50     | 856.97   |
| Португал   | 13 506.00            | 0.4 |          |          |          |          |           |          |          |          |          |          | 0.00     | 0.00     | 0.00      |          |
| Франц      | 13 148 27            | 0.4 |          |          | 40.25    |          | 88.95     | 25.25    | 93.60    | 3.16     | 40.00    | 25.00    | 35.00    | 66.30    | 12 550.00 | 170.08   |
| ХБНГУ      | 11 475 90            | 0.4 | 132.43   | 512.35   | 843.82   | 461.48   | 471.70    | 350.60   | 708.12   | 1 214.61 | 2 917.00 | 419.90   | 370.20   | 1 386.20 | 817.49    | 580.01   |
| Нидерланд  | 9 459.63             | 0.3 | 19.00    |          | 12.50    | 39.85    | 50.58     | 10.00    |          | 147.50   | 4 335.00 | 20.00    | 221.70   | 475.80   | 58.50     | 4 069.20 |
| Кипр       | 7 416.60             | 0.2 |          | 30.68    | 4.37     |          |           |          | 10.00    | 199.03   |          |          | 0.00     | 10.00    | 7 091.52  | 71.00    |
| Чех        | 6 852.29             | 0.2 | 97.50    |          | 1 125.12 | 660.79   | 583.47    | 933.26   | 33.63    | 738.11   | 67.00    | 235.00   | 24.00    | 52.20    | 80.61     | 2 015.04 |
| Люксембург | 6 779.02             | 0.2 |          |          |          |          |           | 357.65   |          | 1 287.35 |          |          | 1 809.30 | 10.00    | 3 118.92  | 195.80   |
| Бельги     | 5 144.98             | 0.2 | 20.00    |          |          | 320.75   | 103.37    |          | 10.00    | 32.00    |          | 2 258.60 | 0.00     | 2 190.80 | 134.46    | 75.00    |
| Люксембург | 3 294.87             | 0.1 | 107.50   | 1 890.00 | 72.00    |          | 1 049.36  |          | 176.02   |          |          |          | 0.00     | 0.00     | 0.00      |          |
| Австри     | 2 293.87             | 0.1 |          |          |          |          | 60.15     | 1 576.00 | 30.00    | 10.00    | 289.00   | 19.00    | 10.00    | 101.80   | 6.40      | 191.52   |
| Польш      | 1 836.26             | 0.1 | 10.00    | 12.00    | 7.50     | 40.80    | 74.50     | 1 511.67 | 89.20    |          | 18.00    | 16.59    | 10.00    | 16.00    | 20.00     | 10.00    |
| Унгар      | 1 247.39             | 0.0 | 36.00    | 40.60    | 8.00     |          | 593.00    | 50.00    | 434.88   |          |          |          | 12.71    | 54.20    | 18.00     |          |
| Словак     | 662.45               | 0.0 |          | 154.89   |          | 41.48    | 0.48      |          |          | 142.60   |          |          | 0.00     | 273.00   | 50.00     |          |
| Швед       | 520.40               | 0.0 |          |          |          |          |           |          |          |          | 12.00    |          | 10.90    | 0.00     | 466.00    | 30.00    |
| Югослав    | 285.07               | 0.0 | 48.00    | 140.06   |          | 6.66     |           |          | 63.46    | 10.00    | 12.00    |          | 4.90     | 0.00     | 0.00      |          |
| Норвеги    | 178.15               | 0.0 |          |          |          |          | 45.00     | 0.15     |          | 12.00    | 10.00    |          | 10.00    | 5.00     | 6.00      | 90.00    |
| Дани       | 90.30                | 0.0 |          |          | 80.30    |          |           |          |          | 10.00    |          |          | 0.00     | 0.00     | 0.00      |          |
| Испани     | 89.60                | 0.0 |          |          |          | 13.00    |           |          | 17.00    | 21.60    | 8.00     |          | 0.00     | 20.00    | 10.00     |          |
| Беларус    | 83.00                | 0.0 |          |          | 3.10     |          | 4.00      | 10.00    |          |          |          |          | 0.00     | 0.00     | 0.00      | 56.00    |
| Грек       | 49.00                | 0.0 |          |          |          |          |           |          |          |          | 5.00     | 44.00    | 0.00     | 0.00     | 0.00      |          |
| Финлянд    | 41.67                | 0.0 |          |          |          |          |           |          | 10.00    |          |          | 10.00    | 8.17     | 7.00     | 0.00      | 6.50     |

**Тусламжийн мэдээ /сонгосон улсуудаар/сая.ам.доллар (хүснэгт 3)**

|    | Хандивлагчид          | 1991         | 1992         | 1993          | 1994          | 1995          | 1996          | 1997         | 1998          | 1999          | 2000         | 2001          | 2002         | 2003         | 2004         | Нийт            |
|----|-----------------------|--------------|--------------|---------------|---------------|---------------|---------------|--------------|---------------|---------------|--------------|---------------|--------------|--------------|--------------|-----------------|
| 1  | Япон Улс              | 26.66        | 35.02        | 51.88         | 57.16         | 75.98         | 61.73         | 43.14        | 49.01         | 63.65         | 40.05        | 75.33         | 23.17        | 37.61        | 26.72        | 667.12          |
| 2  | АНУ                   | 4.06         | 1.47         | 34.14         | 13.33         | 11.78         | 8.88          | 8.11         | 14.04         | 12.82         | 9.41         | 3.24          | 16.00        | 8.65         | 20.65        | 166.57          |
| 3  | <b>ХБНГУ</b>          | <b>0.00</b>  | <b>0.77</b>  | <b>6.80</b>   | <b>9.48</b>   | <b>20.31</b>  | <b>8.07</b>   | <b>10.17</b> | <b>6.14</b>   | <b>16.70</b>  | <b>12.31</b> | <b>17.00</b>  | <b>7.08</b>  | <b>4.90</b>  | <b>8.20</b>  | <b>127.93</b>   |
| 4  | НҮБ                   | 2.39         | 0.90         | 2.33          | 8.06          | 4.00          | 3.41          | 7.30         | 7.46          | 8.13          | 5.55         | 5.57          | 17.79        | 7.85         | 9.87         | 90.61           |
| 5  | Бусад                 | 10.52        | 2.26         | 6.02          | 12.19         | 4.02          | 2.26          | 1.82         | 3.08          | 1.09          | 1.77         | 3.19          | 1.26         | 5.65         | 9.11         | 64.24           |
| 6  | <b>Европын холбоо</b> | <b>0.00</b>  | <b>0.60</b>  | <b>3.24</b>   | <b>0.04</b>   | <b>2.56</b>   | <b>4.44</b>   | <b>7.99</b>  | <b>4.37</b>   | <b>6.88</b>   | <b>5.62</b>  | <b>3.89</b>   | <b>2.56</b>  | <b>6.40</b>  | <b>2.65</b>  | <b>51.24</b>    |
| 7  | АХБ                   | 0.08         | 3.28         | 1.67          | 3.09          | 5.41          | 5.06          | 5.42         | 5.38          | 2.49          | 3.75         | 2.48          | 3.91         | 4.04         | 3.61         | 49.68           |
| 8  | <b>Дани</b>           | <b>0.03</b>  | <b>0.66</b>  | <b>6.77</b>   | <b>3.74</b>   | <b>6.14</b>   | <b>2.08</b>   | <b>4.60</b>  | <b>3.27</b>   | <b>0.47</b>   | <b>1.43</b>  | <b>0.21</b>   | <b>0.50</b>  | <b>0.50</b>  | <b>0.45</b>  | <b>30.85</b>    |
| 9  | <b>Нидерланд</b>      | <b>1.40</b>  | <b>1.52</b>  | <b>0.48</b>   | <b>3.15</b>   | <b>2.74</b>   | <b>0.10</b>   | <b>0.78</b>  | <b>1.36</b>   | <b>3.97</b>   | <b>5.96</b>  | <b>4.91</b>   | <b>0.90</b>  | <b>0.06</b>  | <b>0.00</b>  | <b>27.33</b>    |
| 10 | БНХАУ                 | 0.18         | 0.37         | 0.68          | 0.18          | 0.00          | 2.80          | 0.49         | 0.00          | 0.00          | 3.24         | 0.60          | 7.00         | 3.10         | 1.38         | 20.03           |
| 11 | Австрали              | 0.29         | 0.26         | 0.61          | 2.08          | 1.02          | 1.98          | 2.05         | 1.63          | 2.92          | 0.72         | 0.16          | 0.19         | 0.15         | 0.04         | 14.11           |
| 12 | Швед                  | 0.00         | 0.20         | 0.57          | 1.95          | 0.75          | 0.12          | 0.19         | 0.24          | 0.84          | 1.92         | 1.54          | 2.02         | 1.79         | 0.94         | 13.06           |
| 13 | ДЭМБ                  | 0.00         | 0.00         | 1.07          | 0.00          | 1.47          | 0.02          | 0.03         | 2.12          | 0.57          | 0.08         | 3.03          | 1.97         | 1.20         | 0.66         | 12.22           |
| 14 | <b>Норвег</b>         | <b>0.00</b>  | <b>0.00</b>  | <b>0.00</b>   | <b>0.03</b>   | <b>0.09</b>   | <b>2.22</b>   | <b>1.70</b>  | <b>3.61</b>   | <b>2.23</b>   | <b>1.21</b>  | <b>0.20</b>   | <b>0.60</b>  | <b>0.23</b>  | <b>0.08</b>  | <b>12.19</b>    |
| 15 | БНСУ                  | 0.05         | 0.26         | 1.01          | 0.43          | 0.60          | 0.70          | 0.69         | 0.19          | 0.82          | 1.08         | 1.93          | 0.24         | 1.50         | 1.25         | 10.76           |
| 16 | <b>Франц</b>          | <b>0.00</b>  | <b>0.19</b>  | <b>1.87</b>   | <b>1.75</b>   | <b>1.83</b>   | <b>1.96</b>   | <b>0.00</b>  | <b>0.56</b>   | <b>0.52</b>   | <b>0.00</b>  | <b>0.02</b>   | <b>0.00</b>  | <b>1.60</b>  | <b>0.43</b>  | <b>10.73</b>    |
| 17 | Дэлхийн банк          | 0.00         | 0.00         | 0.05          | 0.08          | 0.15          | 0.10          | 0.00         | 0.00          | 0.97          | 0.00         | 1.49          | 1.56         | 3.58         | 2.71         | 10.70           |
| 18 | <b>Их Британи</b>     | <b>0.00</b>  | <b>1.25</b>  | <b>2.21</b>   | <b>0.94</b>   | <b>1.48</b>   | <b>0.78</b>   | <b>0.56</b>  | <b>0.20</b>   | <b>0.00</b>   | <b>0.50</b>  | <b>0.95</b>   | <b>0.30</b>  | <b>0.02</b>  | <b>0.00</b>  | <b>9.19</b>     |
| 19 | Канад Улс             | 0.00         | 0.00         | 0.00          | 0.03          | 0.00          | 1.54          | 3.58         | 0.10          | 0.17          | 0.00         | 0.01          | 0.09         | 0.07         | 0.00         | 5.59            |
| 20 | Вьетнам               | 0.00         | 0.00         | 0.00          | 0.00          | 0.00          | 0.00          | 0.00         | 0.00          | 0.00          | 0.00         | 0.00          | 0.00         |              |              | 0.00            |
| 21 | <b>Итали Улс</b>      | <b>0.00</b>  | <b>1.50</b>  | <b>2.40</b>   | <b>1.57</b>   | <b>0.00</b>   | <b>0.00</b>   | <b>0.00</b>  | <b>0.00</b>   | <b>0.00</b>   | <b>0.00</b>  | <b>0.00</b>   | <b>0.00</b>  | <b>0.00</b>  | <b>0.00</b>  | <b>5.47</b>     |
|    | <b>Нийт</b>           | <b>45.66</b> | <b>50.51</b> | <b>123.78</b> | <b>119.27</b> | <b>140.32</b> | <b>108.26</b> | <b>98.62</b> | <b>102.75</b> | <b>125.25</b> | <b>94.61</b> | <b>125.79</b> | <b>87.15</b> | <b>88.90</b> | <b>88.74</b> | <b>1,399.61</b> |

Манайд бусад улс хөрөнгө оруулахад таатай хоёр талын эрх зүйн нөхцлийг бүрдүүлэхийг эрмэлзэх нь чухал юм. Монгол Улс, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрийг 34 оронтой, давхар татвараас харилцан зайлсхийх хэлэлцээрийг 27 оронтой байгуулаад байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг манай улсын цаашдын хөгжилд шийдвэрлэхүйц нөлөө үзүүлэхүйц хүчин чадлыг бий болгох, экспортод чухал ач холбогдолтой, оюуны багтаамж өндөртэй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, олон улсын хөдөлмөрийн хуваарьт төрөлжих, дагнах болон хоршин ороход шаардлагатай салбарт голлон чиглүүлэх нь зүйтэй юм.

Манай улсын эдийн засаг, тэр дундаа гадаад худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтцэд сүүлийн жилд гарсан зарим өөрчлөлтөөс харахад дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралд шууд биш ч шууд бусаар өртөж байгааг харж болно.

Тухайлбал АНУ, Европ, Японы эдийн засагт уналт, хямрал нүүрлэх нь хэтдээ манай экспортын давуу тал алдагдах, импортын бараа хямдрах, худалдааны алдагдал улам нэмэгдэх хандлагыг бий болгож байна.

#### ЕХ-ны орнуудын зүгээс Монгол Улсад үзүүлж буй зээл, тусламжийн бараа

Монгол Улсын Сангийн яамны танилцуулгын мэдээгээр 1991-2004 онд Европын Холбооны зүгээс 51.24 сая долларын тусламж үзүүлсэн байгаа бөгөөд тухайлбал ХБНГУ, Дани, Нидерланд зэрэг улсууд Европын Холбооны бусад улсуудтай харьцуулахад харьцангуй их хэмжээний хандив, тусламж үзүүлж байсныг хүснэгт 4-өөс харах боломжтой.

Манай улсад олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага, хандивлагч орны тусламжаар 2008 онд нийт 39 орноос 59.9 сая ам.долларын бараа импортлосон нь 2007 оныхоос 17.7 сая ам.доллар буюу 41.8 хувиар илүү байна. 2008 онд гадаадын тусламжаар импортлосон барааны бүтцийг улс орноор нь авч үзвэл үүнд Европын орнуудын эзлэх хувь тун бага буюу ХБНГУ-д 2.7 хувь ногдож байна. Харин гадаадын зээлийн хөрөнгөөр нийт 15 орноос 24.1 сая ам.долларын барааг нийлүүлснээс Европын Холбооны гишүүн Бельги улсад 16.8 хувь, ХБНГУ-д 4.2 хувь ногдож байна.

Зээлийн барааны 99.0 хувийг засгийн газрын шугамаар оруулж иржээ. Нийт зээлийн 23.9 хувийг Хятадын засгийн газар, 12.1 хувийг Кувейтын засгийн газар, 6.3 хувийг Японы засгийн газар, 3.5 хувийг ХБНГУ-ын засгийн газар, 3.2 хувийг ОХУ-ын засгийн газар, 7.5 хувийг Азийн Хөгжлийн Банк, 6.2 хувийг Дэлхийн Банкнаас тус тус олгосон байна.

#### **ДҮГНЭЛТ**

Монгол Улс эдүгээ нээлттэй, олон тулгуурт, эвсэлд үл нэгдэх гадаад бодлого хэрэгжүүлэхийг зорьж буй бөгөөд дэлхийн эдийн засаг,



улс төрийн гол төвүүдийн нэг болон улам нягтарч буй Европын Холбооны улсуудтай энэхүү бодлогынхоо хүрээнд улс төр, эдийн засаг, боловсрол зэрэг боломжтой бүхий л салбарт харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж байна. Европын Холбооны улсуудтай улс төр, эдийн засгийн хувьд харилцаагаа өргөжүүлэх энэхүү сонирхол нь Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн зорилтоос урган гарч буй бөгөөд Австри, ХБНГУ, Итали зэрэг манай улстай уламжлалт харилцаа бүхий улс орнуудтай эдийн засгийн харилцаагаа улам идэвхижүүлж, худалдаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь Европын Холбоотой харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлд тус дөхөмтэй нэг чухал гарц болох юм.

Даяаршлын үйл явц гүнзгийрэн эрчимжиж, хөгжлийн хурдац түргэсч буй өнөө үед дэлхийн улс орнууд, нэн ялангуяа сул дорой, жижиг, эмзэг эдийн засагтай улс орнууд даяаршлын үр шимээс аль болох жигд хүртэх бололцоог буй болгох, эдгээр орнуудын нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд олон улсын хамтын нийгэмлэгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх нь чухал юм.

Импортын барааны хэмжээ өсч, гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарах болсон, гадаад зах зээлийн “инфляц импорт”-логдож буйг анхаарч бодлогын зохицуулалт хийх, импортын барааг орлуулах бараа бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар Европын Холбооны дэмжлэг туслалцааг үр бүтээлтэй ашиглахад онцгой анхаарах шаардлагатай байна.

### **Ашигласан материал**

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, УБ, 1994.
2. Н.Багабанди. “Шинэ зуун: Даяаршин дангааршиж, дангааршин даяаршихийн учир”, УБ, 2004 он, 115 дахь тал
3. Б.Даш-Ёндон. “Монголын нийгмийн өөрчлөлт”, УБ, 2008 он
4. “Монгол Улсын нийгэм, эдийн засаг 2006 онд” Монгол Улсын Сангийн Яам., УБ, 2007 он. 26 дахь тал
5. “World Development Indicators” /Дэлхийн Хөгжлийн үзүүлэлтүүд/ 2008, Дэлхийн Банк
6. “Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2008”, УБ, 2009 он. 14-р бүлэг, 265 дахь тал
7. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-ийн мэдээ
8. Монгол Улсын Сангийн яамны төсвийн мэдээ
9. Монгол Улсын Сангийн яамны танилцуулга, хавсралт 7
10. [www.open-government.mn](http://www.open-government.mn)
11. [www.eu.europa.eu/external](http://www.eu.europa.eu/external)
12. <http://www.mongolchamber.mn>